



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ**

2018 оны 02 дугаар сарын 05

№ 01/06 АУА-2018/123/СТА-ТЦГ Мандалговь хот

Төлбөр барагдуулах тухай

Аймгийн Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Соёлын төвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар **58,800.00** /Тавин найман мянга найман зуун/ төгрөгийн дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Номын сангийн үйлчилгээний орлого 34,800 /Гучин дөрвөн мянга найман зуун/ төгрөгийг төвлөрүүлээгүй.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 2.6-д /төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаанаас орох орлогыг мөнгөн кастаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг /түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй/ ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана/,

2. Томилолтын мөнгийг 24,000.00 /хорин дөрвөн мянган/ төгрөгөөр илүү тооцож олгосон.

“Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 3.12-т /Албан томилолтын зардлын тооцоог ирснээсээ хойш 5 өдөрт багтаан гүйцэтгэсэн ажлынхаа үр дүнг томилолт олгосон удирдах дээд шатны байгууллага буюу албан тушаалтанд танилцуулан, томилолтын үнэмлэх дээрээ гарын үсэг зуруулж, томилолтоор ажилласан хугацааг батлуулан байр, уналгын хөлс төлсөн баримтыг бүрдүүлсний үндсэн дээр хийж дуусгана/ гэж заасныг тус тус зөрчсөн.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1-д /Улсын болон орон нутгийн төсөв, Засгийн газрын тусгай сан, хөтөлбөр, биеэ даасан эрхийн актаар зохицуулагдааг сан хөтөлбөр батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан орлогыг дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй/, мөн тус журмын 3.1.3-д /Бусдад өгөх төлбөр тооцоог зөрүүтэй тооцоолж олгосон/ гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Төвлөрүүлээгүй орлого болох **34,800.00** /Гучин дөрвөн мянга найман зуун/ төгрөгийг холбогдох албан тушаалтнаар нөхөн төлүүлж, Дундговь аймгийн Төрийн сан банк дахь орон нутгийн төсвийн 100081535090 дугаар дансанд,
2. Илүү тооцож олгосон **24,000.00** /Хорин дөрвөн мянган/ төгрөгийг холбогдох албан тушаалтнаар нөхөн төлүүлж 100080000955 дугаар дансанд 2018 оны 3 дугаар сарын 25-ны дотор тус тус төвлөрүүлэх.
3. Актын биелэлтийг 2018 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн дотор Төрийн аудитын газарт албан ёсоор ирүүлэхийг Эрдэнэдалай сумын Соёлын төвийн төсвийн шууд захирагч Ө.Эрдэнэчимэг, нягтлан бодогч А.Отгонмаа нарт хариуцуулав.

АКТЫГ

ТОГТООСОН:

АУДИТОР:  М.ОЮУН-ЭРДЭНЭ



ЗӨВШӨӨРСӨН:

ЭРХЛЭГЧ:  Ө.ЭРДЭНЭЧИМЭГ

НЯГТЛАН БОДОГЧ:  А.ОТГОНМАА



¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.